

**ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ГИШҮҮДИЙГ ТОМИЛОХ (СОНГОХ),
ТЭДНИЙ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА, ХАВСРАН ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН
ТАЛААРХ БҮГД НАЙРАМДАХ УЛСУУДЫН ҮНДСЭН ХУУЛИЙН
ЗОХИЦУУЛАЛТ**

(Мэдээлэл, лавлагаа)

Г.Билгээ, О.Нарантуяа

	Улсын нэр	Үндсэн хуулийн зохицуулалт
1.	Австри	<p>В.Үндсэн хуулийн шүүх 147.1.Үндсэн хуулийн шүүх нь Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, 12 гишүүн, 6 орлогч гишүүнээс бүрдэнэ. 147.2.Холбооны Ерөнхийлөгч нь Холбооны Засгийн газрын зөвлөсний дагуу Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч, 6 гишүүн, 3 орлогч гишүүнийг томилно. Эдгээр гишүүд болон орлогч гишүүдийг шүүгчид, захиргааны албан тушаалтнууд, хууль зүйн профессоруудаас сонгоно. Бусад 3 гишүүн, 2 орлогч гишүүнийг Үндэсний зөвлөл (Парламентын доод танхим)-ийн санал болгосноор, 3 гишүүн, 1 орлогч гишүүнийг Холбооны зөвлөл (Парламентын дээд танхим)-ийн санал болгосноор Холбооны Ерөнхийлөгч томилно. 3 гишүүн, 2 орлогч гишүүний оршин суух газар нь Холбооны нийслэл Вена хотын гадна байна... 147.3.Үндсэн хуулийн шүүхийн гишүүд, орлогч гишүүд нь хууль зүй, эсхүл хууль зүй, улс төрийн шинжлэх ухааны сургалт дүүргэх бөгөөд мэргэжлээрээ 10 жил ажилласан байна. 147.6...12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гишүүн, эсхүл орлогч гишүүн нь 70 нас хүрсэн бол түүний бүрэн эрхийн хугацаа дууссан гэж үзнэ.</p>
2.	Болгар	<p>147.1.Үндсэн хуулийн шүүх нь 12 шүүгчээс бүрдэнэ. Тэдгээрийн 1/3-ийг Үндэсний Ассамблейгаас сонгоно, 1/3-ийг Ерөнхийлөгч томилно, 1/3-ийг Кассацийн дээд шүүх болон Захиргааны дээд шүүхийн шүүгчдийн хамтарсан хурлаар сонгоно. 147.2.Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг 9 жилийн хугацаатай сонгох буюу томилох ба дахин сонгогдохгүй буюу томилогдохгүй... 147.3.Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь мэргэжлийн болон ёс суртахууны шударга ёсыг өндөр түвшинд баримтлах хуульч байх ба мэргэжлээрээ 15-аас доошгүй жил ажилласан туршлагатай байна.</p>
3.	Босни-Херцеговин	<p>6 дугаар зүйл. Үндсэн хуулийн шүүх 1.Бүрэлдэхүүн. Босни ба Херцеговиний Үндсэн хуулийн шүүх 9 гишүүнтэй байна. а) энэ шүүхийн 4 гишүүнийг Холбооны Төлөөлөгчдийн танхимаас, 2 гишүүнийг Сербийн Бүгд найрамдах улсын Ассамблейгаас тус тус сонгоно. Бусад 3 гишүүнийг Хүний эрхийн Европын шүүхийн Ерөнхийлөгч нь Ерөнхийлөгчтэй зөвлөлдсөний дараа сонгоно. б) Шүүгчид нь өндөр ёс суртахуунтай хуульчид байна. Энэ шаардлагыг хангасан сонгогдох эрхтэй аливаа сонгогч Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн чиг үүргийг хэрэгжүүлж болно. Хүний эрхийн Европын шүүхийн Ерөнхийлөгчийн сонгосон шүүгчид нь Босни-Херцеговин, эсхүл аль нэг хөрш орны иргэн байж болохгүй. с) Анх удаа сонгогдсон шүүгчийн бүрэн эрхийн хугацаа нь огцрох, эсхүл бусад шүүгчдийн зөвшилцлөөр албан тушаалаас нь эгүүлэн татахаас бусад тохиолдолд 5 жил байна. Анх удаа томилогдсон шүүгчийг улиран томилохгүй. Дараа нь томилогдсон шүүгчид нь огцрох, эсхүл бусад шүүгчдийн зөвшилцлөөр албан тушаалаас нь эгүүлэн татахаас бусад тохиолдолд бол 70 нас хүртлээ ажиллана.</p>
4.	Герман	<p>94 дүгээр зүйл. [Холбооны Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн] 1.Холбооны Үндсэн хуулийн шүүх нь Холбооны шүүгч болон бусад гишүүдээс бүрдэнэ. Холбооны Үндсэн хуулийн шүүхийн гишүүдийн талыг нь Бундестагаас, талыг нь Бундесратаас тус тус сонгоно. Тэд Бундестаг, Бундесрат, Холбооны Засгийн газар, эсхүл мужийн холбогдох байгууллагын гишүүд байж болохгүй.</p>

5.	Итали	<p>135 дугаар зүйл. Үндсэн хуулийн шүүх нь 15 шүүгчээс бүрдэнэ. Шүүгчдийн гуравны нэгийг Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгч, гуравны нэгийг Парламентын Танхимуудын хамтарсан хуралдаанаар, гуравны нэгийг Ерөнхий хэргийн болон Захиргааны хэргийн Дээд шүүх томилно. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр Ерөнхий хэргийн болон Захиргааны хэргийн Дээд шүүхээс тэтгэвэрт гарсан шүүгч, 20-иос доошгүй жилийн ажлын туршлагатай их сургуулийн хуулийн зүйн профессор, хуульчийг сонгоно. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг тангараг өргөсөн өдрөөс 9 жил хугацаатай томилох ба улиран томилохгүй. Үндсэн хуулийн шүүгч нь бүрэн эрхийн хугацаагаа дуусахад албан тушаалаа өгч, чиг үүргээ хэрэгжүүлэхээ зогсооно.. Үндсэн хуулийн шүүгчид Парламент, орон нутгийн зөвлөлийн гишүүн, хуульч, хуульд заасан бүх албан тушаал хавсарч болохгүй.</p>
6.	Ливи	<p>148 дугаар зүйл.Шүүхийн бүрэлдэхүүн Үндсэн хуулийн шүүх нь 12 гишүүний бүрэлдэхүүнтэй. Шүүхийн ерөнхий зөвлөл (Higher Judicial Council) давж заалдах шатны шүүхийн дарга нараас 6 гишүүн, Ерөнхийлөгч 3 гишүүнийг, хууль тогтоох байгууллага 3 гишүүнийг санал болгоно. Ерөнхийлөгч болон хууль тогтоох байгууллагаас нэр дэвшигч нь хууль зүй, улс төрийн шинжлэх ухааны өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ 20-иос доошгүй жил ажилласан дадлага туршлагатай байна. 149 дүгээр зүйл. Гишүүний бүрэн эрхийн хугацаа Үндсэн хуулийн шүүхийн гишүүн нь Ливи улсын иргэн, 45 нас хүрсэн, улс төрийн намын гишүүн биш этгээд байна. Гишүүнээр ажиллах хугацаандаа өөр ажил, албан тушаал хашихыг хориглоно.</p>
7.	Македон	<p>109 дүгээр зүйл. Үндсэн хуулийн шүүх нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг Ассамблейн төлөөлөгчдийн олонхын саналаар сонгоно. Бүрэн эрхийн хугацаа 9 жил. Дахин сонгогдохгүй. Шүүгчээр хууль зүйн өндөр мэргэшилтэй хуульчдаас сонгоно.</p>
8.	Өмнөд Африк	<p>174 дүгээр зүйл. Шүүгчийг томилох Шүүгч нь Өмнөд Африк Улсын иргэн байна. 4) Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг Ерөнхийлөгч томилно. 176 дугаар зүйл. Бүрэн эрхийн хугацаа 1) Бүрэн эрхийн хугацаа 12 жил. Дахин томилогдохгүй. Шүүгчээр ажиллах насны дээд хязгаар 70 нас.</p>
9.	Серби	<p>172 дугаар зүйл. Үндсэн хуулийн шүүх нь 15 шүүгчийн бүрэлдэхүүнтэй. Бүрэн эрхийн хугацаа 9 жил. 1 удаа дахин томилогдож болно. Шүүгчдийн 5-ыг нь Үндэсний Ассамблей, 5-ыг нь Ерөнхийлөгч, 5-ыг нь Кассацийн дээд шүүхийн ерөнхий хурлаас томилно. Үндэсний Ассамблей нь Ерөнхийлөгчөөс санал болгосон 10 нэр дэвшигчээс 5-ыг, Ерөнхийлөгч нь Үндэсний Ассамблейгаас санал болгосон 10 нэр дэвшигчээс 5-ыг, Кассацийн дээд шүүхийн ерөнхий хурал нь Дээд шүүх болон Улсын прокурорын зөвлөлийн ерөнхий хурлаас санал болгосон 10 нэр дэвшигчээс 5 шүүгчийг тус тус томилно. Санал болгож буй нэр дэвшигчдийн жагсаалт бүрт автономит мужийн нутаг дэвсгэрээс ирсэн нэр дэвшигчийг заавар томилно. Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, 40 нас хүрсэн этгээд байна.</p>
10.	Словак	<p>134 дүгээр зүйл. 1) Үндсэн хуулийн шүүх нь 13 шүүгчийн бүрэлдэхүүнтэй. 2) Үндэсний зөвлөлийн буюу парламентын санал болгосноор Словакийн Ерөнхийлөгч томилно. Бүрэн эрхийн хугацаа 12 жил. Дахин томилогдохгүй. 3) Шүүгчээр 40 нас хүрсэн, хуулийн сургууль төгссөн, 15-аас доошгүй жил хууль зүйн чиглэлээр ажилласан, Үндэсний зөвлөлд сонгогдсон, Словак улсын иргэн байна.</p>

11.	Словени	<p>163 дугаар зүйл. Үндсэн хуулийн шүүх нь 8 гишүүний бүрэлдэхүүнтэй. Ерөнхийлөгчийн санал болгосноор Үндэсний Ассамблейгаас сонгоно. Шүүгчид нь хууль зүйн өндөр мэргэжилтэй байна.</p> <p>165 дугаар зүйл. Бүрэн эрхийн хугацаа 8 жил. Бүрэн эрхийн хугацаа дууссан ч шинэ шүүгч сонгогдох хүртэл бүрэн эрхээ хэрэгжүүлнэ. Дахин сонгогдохгүй.</p>
12.	Турк	<p>146 дугаар зүйл. Үндсэн хуулийн шүүх нь 15 гишүүний бүрэлдэхүүнтэй. Шүүгчээр хууль зүйн салбарт 20-иос доошгүй жил ажилласан хуульч нь багш мэргэжилтэй бол процессор, дэд профессор цолтой, 20-иос доошгүй жил төрийн албанд ажилласан, шүүгч болон прокуророор 20-иос доошгүй жилийн ажлын дадлага туршлагатай 45 насанд хүрсэн этгээд байна.</p> <p>147 дугаар зүйл. Бүрэн эрхийн хугацаа 12 жил байх ба дахин сонгогдохгүй. 65 нас хүрснээр тэтгэвэрт гарна.</p>